

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ ЦЭРЭНБААТАРЫН АЛТАНЦАЦРАЛЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах” зорилтын хүрээнд”							
1.	Арга хэмжээ 1.1 Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах	Төлөвлөгөөний хэрэгжилт	10 удаа хуралдсан	Төрийн албаны салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагаа бүрэн хэрэгжсэн байна.	Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хуралдаанд танилцуулж, батлуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Төлөвлөгөөний дагуу Салбар зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг ханган, хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг тухай бүр боловсруулан хуралдааныг дэгийн дагуу хуралдуулан, хурлаас гарсан шийдвэрийг 3 хоногийн дотор эцэслэн албажуулан ажиллалаа. Энэ жилийн эцсийн байдлаар Салбар зөвлөлийн хуралдаан 13 удаа хуралдуулж дараах асуудлуудыг хэлэлцүүлж шийдвэр гаргуулсан байна. Үүнд:-Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын хэсэг томилох тухай;Албан тушаалд нэр дэвшүүлж, санал болгох тухай; Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.2-т заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам болон харьяа	2024.01.01-2024.12.31	100

					байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдад Эрхэлсэн түшмэлийн зэрэг дэв шинээр болох ахиулан олгуулах санал авах тухай; Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яам болон харьяа байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэв шинээр болон ахиулан олгох тухай; Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, Ерөнхийлөгчийн 2024 оны 84 дүгээр зарлигаар баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-д заасны дагуу Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх болзол хангасан албан хаагчдыг Төрийн албаны тангаргаа өргүүлэх тухай; Төрийн жинхэнэ албан хаагчийн албан тушаалын тодорхойлолтыг батлуулах зөвшөөрөл авахаар ТАЗ-д хүргүүлэх тухай зэрэг 23 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.		
2.	Арга хэмжээ 1.2. Салбарын зарим Удирдах ажилтны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулан мөрдүүлэх	Албан тушаалын тодорхойлолт	3	Шинэчлэн мөрдүүлэх шаардлагатай албан тушаалын тодорхойлолтуудыг батлах зөвшөөрөл авахаар Төрийн албаны зөвлөлд холбогдох материалыг хүргүүлсэн байна.	Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 3 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын 3.9-т заасны дагуу Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 144, гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 137, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 133 албан тушаалын тодорхойлолтыг Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, батлах зөвшөөрөл авч, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 46 албан тушаалын тодорхойлолтыг батлах зөвшөөрөл авахаар Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил,	2024.01.01 2024.12.31	100

					хамгааллын ерөнхий газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дарга, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирлын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлөөс санал авч, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан.		
3.	Арга хэмжээ 1.3. Яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлийн эрх хэмжээний албан тушаалын сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүлээн авах, хянах, зарлуулах, шалгалтын комисс байгуулах, зохион байгуулах, нэр дэвшүүлэх, томилох	Албан тушаалын сул орон тоог нөхөн сонгох, шалгаруулалт тушаал	189	Албан тушаалын сул орон тоонд холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулагдаж, албан тушаалын орон тоо нөхөгдсөн байна.	Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлөөс салбарын хэмжээний төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх, төрийн үйлчилгээний удирдах албаны сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалт зохион байгуулах комиссыг салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тухай бүр байгуулан ажиллалаа. Энэ онд Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлөөс яам, агентлаг, харьяа байгууллагын удирдах 38, гүйцэтгэх 202 нийт 240 сул орон тооны тусгай шалгалтыг зохион байгуулан ажиллалаа. Тусгай шалгалтыг Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын дагуу зохион байгуулав. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу сул орон тоог олон нийтэд мэдээлэх,	2024.01.01 2024.12.31	100

					төрийн жинхэнэ албан хаагч төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллах боломжийг хангах үүднээс уг албан тушаалд ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдын хүрээнд 5 хоногийн хугацаанд Зөвлөлийн цахим хуудас, Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо цахим системээр мэдээллэн ажиллаж байгаа бөгөөд журам батлагдснаас хойш нийт 240 сул орон тооны мэдээллийг салбарын хэмжээнд нэгтгэн нийтэд мэдээлж ажилласан байна. Төрийн албаны зөвлөлөөс энэ оны 9 дүгээр сард Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаад салбарын бусад яамдаас 4 дахин их сонгон шалгаруулалт зохион байгуулж байгаа, салбар зөвлөлийн үйл ажиллагаа хуулийн дагуу явагдаж байна гэж дүгнэсэн.		
4.	Арга хэмжээ 1.4. Харьяа байгууллагуудын төсвийн ерөнхийлөн захирагч нарын Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, албажуулах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэлийн үнэлгээ хийлгүүлэх, үнэлгээний мөрөөр урамшуулах, хариуцлага тооцох ажлыг зохион байгуулах	Гүйцэтгэлийн төлөвлөгөө	6	Харьяа байгууллагуудын Гүйцэтгэлийн төлөвлөгөө албажиж, үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа агентлагууд, байгууллагуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянаж, албажуулах ажлыг зохион байгуулсан. Монгол улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын дагуу 2024 оны эхний хагас жил болон жилийн эцсийн Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлтийг Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод	2024.01.01-2024.12.31	100

					аудитын газраар үнэлүүлэх ажлыг зохион байгууллаа.		
5.	Арга хэмжээ 1.5. Харьяа байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын хувийн хэргийг шинэчлэн баяжуулах	Хувийн хэргийн шинэчлэл	12	Харьяа газрын дарга, захирлуудын хувийн хэргийг стандартын дагуу шинэчилсэн байна.	Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам”-ын дагуу агентлаг болон яамны харьяа байгууллагуудын удирдах 15 ажилтны хувийн хэрэгт баяжилт хийж ажилласан.	2024.01.01- 2024.12.31	100
6.	Арга хэмжээ 1.6. ХНХЯ-ны төрийн албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт		Хөтөлбөрийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллана.	Төрийн албан хаагчдын Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ оны эхний хагас жилд Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу 2024 оны хагас жилээр 144 албан хаагчид холбогдох журмын дагуу урамшуулалд олгосон байна. Ажлын зайлшгүй шаардлагаар удирдлагаас өгсөн шахуу хугацаатай үүрэг даалгаврыг биелүүлэн илүү цагаар ажилласан албан хаагчдад цалингийн санд багтаан илүү цагийн хөлсийг тооцож олгох Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын дагуу 10 албан хаагчид илүү цагийн хөлсөнд 3,5 сая төгрөгийг тооцож олголоо. Төрийн албан хаагчдын нийгмийн батлагааг хангах хүрээнд төрийн албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардалд өдрийн 3 мянга,	2024.01.01- 2024.06.31	100

					өдрийн хоолны мөнгөнд 25 мянган төгрөгөөр тооцон, сар бүр олгохоор өөрчлөлт орж, эхний хагас жилд 249,1 сая төгрөг олгосон байна. Мөн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шинээр гэр бүл болсон 1 ажилтанд 800 мянган төгрөг, ар гэрт нь гачигдал гарсан 9 ажилтанд 5.6 сая, төгрөг, өөрийн зардлаар мэдлэг боловсролоо дээшлүүлэхээр их дээд сургуульд суралцаж байгаа 3 ажилтанд 2.4 сая төгрөгийн дэмжлэгийг олгосон.		
7.	Арга хэмжээ 1.7 Төрийн албаны тухай хуулийн дагуу тусгай шаардлага хангасан төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгох санал гаргах, зэрэг дэв олгуулах	Зэрэг дэвийн санал	108	Салбарын хэмжээнд төрийн захиргааны албан хаагчид албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгуулсан байна.	Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-д заасан болзол хангасан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон харьяа байгууллагуудын 17 төрийн захиргааны албан хаагчдад Эрхэлсэн түшмэлийн албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгуулах, Ахлах болон Дэс түшмэлийн зэрэгт хамаарах албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв ахиулах болон шинээр олгох асуудлыг Төрийн албаны зөвлөлийн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн 85 дугаар тогтоолоор 97 албан хаагчийн зэрэг дэвийн асуудлыг шийдвэрлэсэн. Мөн Салбар зөвлөлийн 12 дугаар сарын хуралдаанаар салбарын төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгуулах асуудлыг хэлэлцэхээр яам болон агентлагуудаас материал авч байна.	2024.01.01-2024.12.31	100

8.	Арга хэмжээ 1.8 Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх болзол хангасан албан хаагчдын материал хүлээн авах, хянах, Тангараг өргөх ёслолын ажиллагаа зохион байгуулах	Журмын дагуу зохион байгуулсан байх	158	Салбарын хэмжээнд тангараг өргүүлсэн байна.	Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх болзол хангасан албан хаагчдын материалыг харьяа агентлагуудаас хүлээн авах, хянан Төрийн албаны зөвлөлийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн 83 дугаар тогтоол гарган, Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх заалт, Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-д заасны дагуу 62 албан хаагчийг Төрийн албаны өдрөөр Төрийн албаны тангаргаа өргүүлж, 54 албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг 12 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулахаар Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн 73 дугаар тогтоол гаргалаа.	2024.01.01-2024.12.31	100
Зорилт 2. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн 71 дүгээр зарлигаар батлагдсан Монгол Улсын цол хүртээх, одон медалиар шагнах журам, ХНХЯ-ны шагналын журмыг хэрэгжүүлэн ажиллах хүрээнд”							
1.	Арга хэмжээ 2.1. Байгууллага, иргэдээс Төрийн дээд одон медалиар шагнуулахаар ирүүлсэн хүмүүсийн материалыг хүлээн авах, хянах, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжлах	Шагналын журмыг хэрэгжүүлэн ажиллах	68	Шаардлага хангасан хүмүүсийн Засгийн газрын ХЭГ-т материалыг уламжилсан байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 71 дүгээр зарилагаар батлагдсан "Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ын дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт олон жил, үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийг шагнуулахаар байгууллага, хамт олноос нь нэр дэвшүүлсэн материалыг хүлээн авч судлан, шийдвэрлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. Энэ оны эхний хагас жилийн байдлаар төрийн дээд одон медалиар шагнуулахаар Гавьяат багш цолоор 1, Үйлчилгээний гавьяат ажилтан цолоор 1, Аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 10, Алтан гадас одонгоор	2024.01.01-2024.06.31	100

					44, Хөдөлмөрийн хүндэт медалиар 82 хүнийг шагнуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт уламжиллаа.		
2.	Арга хэмжээ 2.2. Байгууллага, иргэдээс салбарын шагналаар шагнуулахаар ирүүлсэн хүмүүсийн материалыг хүлээн авах, хянах, шаардлага хангасан хүмүүсийг журмын дагуу шагнах асуудлыг шийдвэрлэх	Шагналын журмыг хэрэгжүүлэн ажиллах	2217	Шаардлага хангасан хүмүүсийг журмын дагуу салбарын шагналаар шагнасан байна.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2016 оны А/258 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын шагналын журам”-ыг үндэслэн эрхэлсэн ажилдаа олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа хүмүүсийг ХНХ-ын Сайдын тушаалаар шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулан ажиллалаа. Эхний 06 сарын 10-ны өдрийн байдлаар Засгийн газрын шагнал “Хөдөлмөрийн тэргүүний ажилтан” тэмдгээр 551, “Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан” тэмдгээр 325, “Хүндэт жуух” бичгээр 421 хүнийг шагнасан.	2024.01.01- 2024.06.31	100

Хоёр. НЭМЭЛТ ҮҮРЭГ ДААЛГАВАР (АРГА ХЭМЖЭЭ)-ЫН БИЕЛЭЛТ

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Мэдээллийн технологийн хүний нөөцийн аудит хийх		-	Төлөвлөгөөний дагуу аудит хийгдсэн байна	Төрийн албаны зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөний дагуу Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн чиг үүрэг хэрэгжүүлдэг хүний нөөцийн бүрдүүлэлт, сургалт хөгжлийн бодлогын хэрэгжилт, үр дүн сэдэвт аудитыг яам болон 4 агентлагийн хэмжээнд зохион байгуулж, дүнг нэгтгэн төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.	2024.09.11- 2024.10.01	100
2.	Удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулах		-	Салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	Гэр бүр, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлогын шинэчлэл, засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд	2024.12.05	100

					тусгасан асуудлууд, салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт, тулгамдаж буй асуудлын талаар санал солилцох, зөвлөлдөх, аймаг дүүргийн салбарын хүрээнд 2024 оны үйл ажиллагааны үр дүнг хэлэлцэж, цаашид анхаарах асуудлаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангахад зорилго бүхий салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулах ажлын хэсгийн Нарийн бичгийн даргаар ажиллаж, 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан.		
--	--	--	--	--	---	--	--

Гурав. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
			1	2	3	4	5
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиглэлээр зохион байгуулах сургалт, семинар, хөтөлбөрт хамрагдах	Суралцсан кредит цаг	-	Хариуцсан ажлын чиглэлээр шинэ мэдээлэл, ойлголттой болсон байна.	-Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан 7:4:10 арга зүйн сургалтуудад оролцож шинэ мэдлэг, мэдээлэл авсан. -ТАЗ-өөс зохион байгуулсан Салбар зөвлөлийг арга зүйгээр хангах цаг үеийн сургалт, семинарт оролцсон.	2024.01.01-2024.12.31	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

хариуцсан ахлах шинжээч
(Албан тушаал)

(Нэр, гарын үсэг)

(Огноо)